

МОНГОЛЧУУДЫН ХҮҮХДИЙН ОВОО ТАХИЛГА

С.Бямбадорж¹, Б.Баатархүү²

¹ Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Угсаатан судлалын тэнхим

² ШУА-ийн Түүхийн хүрээлэн, докторант

Түлхүүр үг: овоо, хүүхэд, тахилга, шүтлэг

Монголчуудын эртнээс нааш уламжлан ирсэн зан үйлийн нэг бол овоо тахилга юм. Төв Ази даяар тархсан энэ шүтлэг нь уул ус, тэнгэр болон өвөр дээдсийн зэрэг эртний шүтлэгийн олон хэлбэрийн зааг, нийлэх цэг болдогоороо онцлогтой билээ.

Монголчуудын овоо тахилгын үүсэл гарал, зан үйлийн талаар Орос, Европын нилээд эрдэмтэд судалсан байна. Тухайлбал, В.Хайссиг, М.Татар Фоссе, Ч.Бауден, Т.Гото, Шрейдер, Н.Л.Жуковская, Л.Н.Абаев, К.М.Герасимова нар болон бусад эрдэмтэд бүтээлдээ Монголчуудын овоо тахилгын талаар дурдсан байна. Мөн Өвөр Монголын эрдэмтдийн гаргасан зан дадхалын холбогдолт олон бүтээлд монголчуудын олон угсаатны нийтлэгийн овоо тахилгын зан үйлийн талаар дурдсан байдаг.

Дээр дурдсан эрдэмтдийн бүтээлээс шүүн үзвэл, нэн олон овооны төрөл хэлбэрийг бүртгэсэн байдаг. Тухайлбал, Тэнгэрийн овоо, овог аймгийн овоо, жанжин овоо, дурсгалын овоо, хурах (хуран цуглах) овоо, онгон овоо, хошуу овоо, шавь нар овоо, отог овоо, сүм хийдийн овоо, сүлд овоо, ноёны овоо, айл усны овоо, малын овоо, нуур усны овоо, тангарагийн овоо, зам давааны овоо, хараалын овоо гэх мэт олон төрөл зүйл овоо байдаг ажээ.

Энэ олон зүйлээс судлаачдын анхааралд төдийлөн өртөөгүй нэгэн төрөл овоо нь “Хүүхдийн овоо” юм. Хүүхдийн овоо нь Монгол нутаг даяар тархмал байсан нь угсаатан судлалын хээрийн шинжилгээний судалгааны үр дүнгээс мэдэгдэж байна.¹ Ялангуяа Халхын зүүн нутаг, Өвөр монголд одоо ч хүүхдийн овоог тахисаар байна.

Нутаг нутгийн заншил адилгүйгээс хүүхдийн овоо тахих зан үйл ч олон янз байжээ. Гэвч ерөнхийдөө үрийн хутаг гуйх буюу үр хүүхдэд нь аливаа муу ёрын гай барцад тохиолдохоос сэргийлэн ямар нэг уул хайрхан, агуй, дэл хад, хүн дүрстэй чулуу, булаг ус, нуур, гол, ганц мод зэрэг онцгой газар овоо босгож даатган тахидаг. Мөн зарим нутагт хүүхдийн овоог олон замын уулзварын хажууд босгосон ч байдаг². Энэ нь монголчууд эндсэн хүүхдийг олон замын уулзварт гээдэг заншилтай холбоотой бөгөөд тэнд хүүхдийн овоогоо босгон тахидаг нь алдсан үр хүүхдээ эргүүлэн олж авахын бэлгэдэл утгатай бололтой. Монголын ардын аман зохиолд ах дүүс, анд нөхөд салж явахдаа эргэн уулзахын бэлгэдэл болгож салаа замын уулзварт мод тарьж буй өгүүлэмж олонтаа тохиолддог нь хүүхдийн овоог олон замын уулзварт босгон тахидаг ёстой агуулгын хувьд төстэй байна.

Мөн манай орны зарим нутагт хүүхэд осол эндэлд орж нас барахад тэрхүү газар нь мод тарьдаг ёс байдаг. Зарим газар Утай, Цастын орны Мөнхзуу (Лхас) Амдуугийн Гүмбүм, Лавранд даатгаж тэр газраас авчирсан адист, шороо чулуугаар сан дарж хүүхдийн овоо босгож тахидаг.³

Халхын Сэцэн хан аймгийн Халх гол хавиар нутаглагсад “Вангийн цагаан уул”анд хүүхдийн овоо босгож, лус тахих үед хамруулан тахиж, үрийн хутаг гуйж, хүүхдийн найр хийдэг байжээ.⁴ Өмнөговь аймгийн зарим нутгийнхан “Гурван түшмэл” хэмээх хадны “Хөвгүүн” хаданд хүүхдийн овоо босгон тахиж байсан тухай мэдээ байна.⁵ Мөн Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын өөлдүүд нутгийнхаа “Таван салаа шанд”-ны эхэн удган улиасыг тахихдаа хадаг бес уяж, хүүхэд барилдуулж, хүүхдэд хувь

болгож чихэр, боов өгч байснаас үзэхэд⁶ энэ нь хүүхдэд зориулсан тахилга байсан бололтой.

Монгол нутаг дахь хүүхдийн овоо нь нэг ба долоон тоотой байх нь элбэг байдаг.⁷ Монголчуудын ардын аман ярианд “Дотоод энгэртээ долоон хүүхэдтэй бол” гэж ерөөдөг тооны бэлгэдэл нь хүүхдийн овооны тоотой ижил буй. Зарим нутагт “Долоон бурхан (Долоон өвгөн)” тахисан долоон овоог мөн хүүхдийн овоо гэдэг. Долоон овооны байрлал нь гол овооны зүүн баруун талд гурав гурван шавь овоотой. Зарим нь гол овооны гурван талд хоёр хоёр шавь овоотой байдаг.

Судалгааны материалаас үзэхэд ихэнх нутагт “Долоон бурхан одны сан” уншиж хүүхдийн овоогоо тахиж байжээ. Монголчууд долоон бурхан одыг үр хүүхэд заяагч, гал голомтын ивээгч хэмээн үзэж сүслэн шүтэж түүнтэй холбоотой элдэв зан үйлийг хийдэг байсан байна. Долоон бурхан одыг хүүхэд өвдөх, хүүхэд тогтдоггүй айл нийтлэг тахиулдаг. Манай зарим нутагт долоон хүүхдийн найр хийх заншил бий. Үр хүүхэдгүй айл үрийн хутаг гуйхдаа өдрийн цагт өрхөө бүтээж, лаа, зул асаан айлын долоо буюу түүнээс олон хүүхдийг залж, дайлж цайлж, дуу хуур, хөгжөөн цэнгэл хийдэг байна. Энэ нь долоон бурхан одыг гэртээ залж найрлуулж, тэндээс үрийн хутаг гуйж буй зан үйл юм.⁸ Монголын бусад зан үйлд ч долоон бурхан одонд айл гэрийн аз жаргал, өнөр өтгөн байлгахыг гуйж даатгах нь элбэг байна.

Хүүхдийн овоог голдуу зун, намар тахидаг. Хүүхдийн овоо тахихдаа, овоо тахилгын долоон хүүхэд буюу олон хүүхэд төрүүлсэн элэг бүтэн өндөр настай ээж хүнээр эрхлүүлдэг. Ингэснээс зарим нутагт ийм овоогоо яваандаа “Ээж овоо”, “Найнай овоо”⁹ гэдэг ба зарим нутагт “Дарь эх” овоо¹⁰ ч гэж нэрлэдэг ажээ. Ийм овоог тахихдаа айл болгон “овоон сацлын дээж” гэж ааруул, хурууд, бяслаг, боов боорцог, чихэр бэлдэж авчирдаг бөгөөд хот усныхаа ахмад настай итгэл хүндтэй хүн нь сацлын дээжийг элбэг бэлтгэдэг. Овооны сан тавиулахаар элэг бүтэн гэрийн долоон настай долоон хүүхэд цуглуулж, хэдэн өдрийн өмнөөс долоон бурхан одны тахилгын сангийн уншлагаас нэг бадаг заадаг байна.¹¹ Ихэнх нутагт долоон настай долоон хүүхэд олоход бэрх байдаг учир элэг бүтэн гэрийн арван гурван наснаас доош долоон хүүхэд оролцуулдаг байжээ. Зарим нутагт ийм 7 хүүхэд олддоггүй учир хот усны ахмад нь хадаг самбай авч нилээд холоос хүүхэд залдаг нь ч байв. Тэднийг овооны энгэрт баруунаас зүүн тийш нэг мөрөөр суулгаад бусад хүүхдийг уг долоон хүүхдийг тойруулан суулгаж томчуул гадуур нь суух буюу зогсоно. Овоон сацлын дээжийг том тэвшинд овоолон хийж заримыг нь овооны талбиур болох хавтгай чулуун дээр тавина. Овооны дөрвөн талд мод хатгаж түүндээ хадаг самбай, хүүхдийн баринтаг, бойтог, өлгий, хонх, зоос, тэнгэрийн сум, дун лавай, янзаганы шийр, бодонгийн соёо, чонын савар, солонгын арьс зэрэг бага хүүхдийг хамгаалах болон хүүхдэд ээлтэй бэлгэдлийн зүйлсийг өлгөнө.

Зарим нутагт хар халзан хонь гаргаж толгой ба уураг сүүлийг нь овоондоо өргөж тахидаг. Ингээд ахлагч нь голд суусан хүүхдээр арц хүж унгасгуулж овоогоо буруугаар 3 эргэж, буй бүх юмаа ариутгасны дараа долоон хүүхэд:

“Хүй ихэт 99 тэнгэр

Хөвчин ихэт 77 этүгэн эх

Ерэн түмэн одны дундаас

Долоон бурхан одноо

Зул хүж, жимс архи

Халзан цагаан хонь бэлдэж

Ариун тахил тахин өргөнөм

Хутаг хишиг энэ өдөр энд оршитугай

Ийм жилд тийм омогт

Өчүүхэн хүн гарахыг

Заяах болтугай...”¹² гэж “Долоон бурхан одны тахилгын сан”-г эрхлэн

уншихад тахилгын ахлагч нь залгуулан уншиж төгсгөдөг байна. Сан уншаад

даллага авахаас өмнө бүх хүмүүс долоон бурхандаа мөргөж залбирдаг. Даллага авахад сангийн долоон хүүхэд нэг бүр хадаг уясан тэнгэрийн сум барьж, овоогоо буруугаар долоо эргэж "хурай хурай" хэмээн гүйлдэж тэнгэрийн сумаараа овооны модонд өлгөсөн зүйлсийг дэлдэж явдаг. Энэ үед 4 зүгт тэнгэр өөд сацлын дээжээ өргөхөд бусад хүүхэд хормойдоо сацал түүдэг. Арван гурваас дээш настай хүн сацал түүж болдоггүй. Долоон хүүхдийн хувийг үлдээж, бусад дээжийг бүгдийг нь цацна. Зарим газар халзан хониор тахилга өргөдөг боловч сацалдаа мах оруулдаггүй. Сацалаа өргөөд овоо тахилга дуусч, ахлагч нь овоо тахисан өтөгийг (ууц) таллан хишиг түгээдэг. Дараа нь бүгд овооны дэргэд сууж хүүхдийн бөх барилдахыг үзэж, сацлын дээжээс идэцгээдэг байжээ.¹³

Хүүхдийн овоо тахихад хэдэн зүйлийн онцгой заншилтай. Үүнд: овоогоо нар зөв эргэсэн нь аргын ёс аавын мөр гэдэг. Буруу эргэсэн нь билгийн ёс ээжийн мөр гэдэг. Овооны хишгийг гэртээ авч харих цээртэй. Авч харивал долоон бурхан од нь "Миний юмыг идсэн чинь боллоо, бас авч явдаг нь юу буй" гэж хилэгнэн чөтгөр шуламыг дагуулж хорлодог гэдэг. Овооноос харихдаа даллага авахаар овоонд зүүлгэсэн баринтаг зэрэг идээ авч нандигнан хадгалдаг заншилтай.

Халхын зүүн өмнөд хэсэг, Харчин, Хорчин, Найман, Цахарын зарим нутагт ээж овоо, найнай овоо нэртэй хүүхдийн овоо нилээд байжээ.

Хорчин, Харчинд хүүхдийн овоог "найнай овоо" гэж нэрлэдэг. Хорчингууд нутаг усны хамгийн өндөр насалсан элэг бүтэн, эмгэн хүнийг сонгон авч "Найнай" болгодог. Овоогоо тахихад 13 наснаас доош хүүхэд бүхний магнайн дунд хөө түрхэн чөтгөрийн хорлолоос зайлуулах дом хийж найнай овоондоо гаргадаг. Овоон дээрх бургас модондоо таван өнгийн хив торго зүүлгэж, цагаан ирэг хонины бүхэл шүүсээр овоондоо тахил өргөдөг. Найнай болсон эмгэн нь овооны оройн дээр гарч, нутаг усны эздэд тахилга тавьсны дараа хив хадаг уясан даллагын сум барьж хүүхдийн хишиг буяныг хурайлан даллаж эрүүл мэнд өсч бойжихыг ерөөнө. Ингээд айл айлын хувь нийлүүлсэн овоон сацал, тахилгын хишгийг Найнай эмгэн нь овооны оройгоос цацахад олон хүүхэд булаалдан түүдэг. Сацлын боорцог, ааруул, чихрийг арвин их түүсэн хүүхдийг "жилдээ зөнтэй, ондоо омогтой" гэж бэлэгшээдэг. Дараа нь овоонд өргөсөн хонины хааг хүүхдэд хуваан өгч бусад хүмүүст амсуулдаг. Ингээд хүүхдүүдийг барилдуулж, овоон дээрээ найрлаад тарцгаадаг байжээ.

Энд өгүүлэгдэж байгаа "Найнай" бол үр хүүхдийг ивээн тэтгэгч, эрүүл саруул өсгөгч, эмэг тэнгэр буюу богд эмэг юм. Найнайг:

Бүдүүн цагаан царайтай
Бүлтийх нүд бүрэн их
Өргөн цагаан царайтай
Үмхэх ам шүд цагаан
Саримсаг цагаан царайтай
Сугта хамар бүрэн хос
Ахай найман хавирганд
Асрах сүү хөх их
Хас цагаан цээжинд нь
Халуун уурагтай хөх хос...
Уурын дээжийг өргөмүү
Удган Найнай амс¹⁴

Хорчины "Найнайн заллага"-д:

Барчид зовлон өвчнийг
Босгож авдаг Богд цагаан Найнай...
Талын зоогийн хуараар
Тан талхаа найруулсан
Тахал зовлон тулсан хүнийг
Туслаад авдаг Найнай Богд...

Эрдэнэ сайхан модтой
Эхний модон дээр залдаг юм шүү
Үр ачийг хайрлаад
Цагааруулаад авдаг Найнай Богд¹⁵ хэмээн

дүрсэлсэн байдаг:

Үүнээс үзэхэд, Найнай нь үр хүүхдийг төрүүлэн өсгөдөг эх тэнгэр төдийгүй эмчлэн эдгэрүүлэгч эмч домч, удган байна. Монголын дорнод нутагт олонтаа тааралдах “ээж овоо” ч түүнтэй холбоотой буй заа.

Богд эмгийг удган модтой, овоотой холбон үздэг явдал аль ч нутагт байсан бололтой.

Хожим хүүхдийн овоо тахилгад буддийн шашны нөлөө тусч тахих ёс, шүтээн сахиус нь өөрчлөгдсөн нь ажиглагдаж байна. Их хүрээнд байсан хүүхдийн шүтдэг овоо нь ууланд байдаггүй, харин өндөрлөг газарт өөрсдийнхөө тоглодог газар босгодог. Хүүхдийн овооны ёслол нь зуны сүүл сард болдог. Хүүхдүүд овоогоо тахихдаа мөнгө цуглуулж, тахилгыг удирдах ахмад настныг сонгож авах ба тэрээр уг мөнгөөр овооны тахилгад зайлшгүй хэрэгцээтэй зүйлсийг бэлтгэдэг. Мөнгө хүрэлцвэл хонь, хүрэхгүй бол хуушуур, цагаан идээ бэлдэж, сэржимд рашаан хэрэглэдэг байжээ. Архийг бурхан таалдаггүй, тамхинд лус дургүй учир овоо тахих лам нь архи ууж, тамхи татдаггүй байх шаардлагатай байсан гэдэг. Хүүхдийн овоо тахилгад зөвхөн лусын сан уншиж, хонхноос өөр зэмсэг хэрэглэдэггүй байсан¹⁶ зэрэг нь ламын шашны ёс хүүхдийн овоо тахилгад шингэсэн нь харагдаж байна.

Хүүхдийн овооны нэгэн өвөрмөц хэлбэр бол “Хуврагийн овоо” юм. Энэ нь хүрээ хийдэд шавилан сууж буй лам хүүхдүүдэд зориулан тахидаг овоо юм.

Монголд буддийн шашин дэлгэрснээс хойш томоохон хүрээ хийдүүдийн дэргэд “хуврагийн овоо” тахидаг болжээ. Тухайлбал, хуучин Сэцэн Хан аймгийн Хөвчийн Жонон Вангийн хошууны Гилбэрийн хийд, мөн аймгийн Дайчин бэйсийн хошууны Дашчойнхорлон хийдэд хуврагийн овоог жил болгон тахиж байжээ.¹⁷ Мөн Их Хүрээний “Тасганы овоо” ч бас хуврагийн овоо байсан байна.¹⁸

Хуврагийн овоог ууланд босгодоггүй, сүм хийдийнхээ ойролцоо нам газар босгодог. Хуврагийн овоо тахилгыг хийдийн лам нар эрхлэн явуулах ба тахилгын зардлыг хийдийн жасаас гаргадаг байжээ. Овоо тахилгад хүүхдүүдийг нарийн дэг жаягаар оролцуулдаг. Тухайлбал, хар хүүхэд оролцохгүй, зөвхөн хувраг хүүхэд оролцоно. Хувраг хүүхдүүд номын дамжаа барихын өмнө овоо тахилгадаа оролцдог байна. Мөн уншлага төгссөн хувраг хүүхдийг оролцуулахгүй. Учир нь уншлага төгссөн хувраг хүүхэд овоо тахилгад оролцохоо больж, насанд хүрсэн ламын тоонд ордог журамтай.¹⁹

Хуврагийн овоог жил болгон зуны сард тахина. Овоо тахилгад зориулж боов, боорцог, цагаан идээ бэлтгэнэ. Тахилга эхлэхэд лам нар ном хурсны дараа хуврага хүүхдүүдийг морьтой лам дагуулан явж явганаар уралдуулна. Үүний дараа хүүхдүүдийг бөх барилдуулна. Тахилгын эцэст түрүүлсэн хүүхдүүдэд сахиус зүүн өгч, тахилгын идээнээс хувь тараадаг байжээ. Хуврагийн овоо тахилга нь хүүхдийн овооны хувирмал хэлбэр байсан бололтой.

Эдүгээ цагт хүүхдийн овооны тахилга нилээд мартагдаж буй боловч монгол орны зарим нутагт хүүхдийн овоог сэргээн тахиж байна. Тухайлбал, Хэнтий аймгийн Баян-Овоо сумын өндөр настан Баянмөнх, Гомбо, Чүлтэм нар сумын төвийнхөө баруун хойно хуучин Ваангийн хийдийн туурийн дэргэд 1990 хэдэн оноос хүүхдийн овоог сэргээн жил бүр зургадугаар сарын нэгэнд хүүхдийн баяртай хамтатган тахидаг уламжлалтай болжээ.²⁰ Уг тахилгад хүүхдүүдийг эцэг эх нь дагуулан очиж, овоонд цагаан идээ, чихэр, боов өргөдөг ба хүүхдүүд концерт тоглон, буухиа гүйлтээр уралдаж, мөн барилддаг ажээ.

Эцэст нь тэмдэглэхэд монголчуудын нийгмийн хэрэгцээ шаардлагаас үүдэн үрийн хутаг гуйх, үр хүүхдэд нь аливаа муу ёрын гай барцад тохиолдох зэргээс сэргийлэн хүүхдийн овоо босгон тахиж иржээ. Гэвч нутаг нутгийн заншил

адилгүйгээс хүүхдийн овоогоо "ээж овоо", "найнай овоо", "дарь-эх овоо" гэж нэрлэж ирсэн байна. Хожим буддийн шашин дэлгэрснээс хойш хүүхдийн овооны нэгэн шинэчлэгдсэн хувилбар болох "хуврагийн овоо" бий болжээ. Хүүхдийн овоо тахилгын зан үйлд долоон овоо, долоон бурхан одны сан, долоон хүүхэд, долоон хүүхэд төрүүлсэн ээж хүн зэрэг ойлголтууд нь хүүхдийн овоо тахилгын нэгэн өвөрмөц юм.

Резюме

**С.Бямбадорж
Б.Баатархүү**

Авторы рассматривают ритуал жертвоприношения у "детского обо" его функцию и значение. Проведенные исследования в восточном регионе Монголии, свидетельствуют о равномерном распространении ритуала, хотя они называются по разному. Цель ритуала жертвоприношения у детского обо была вопрошение о рождении ребенка, ограждение детей от злых духов, болезной, несчастных случаев.